Хурлын тэмдэглэл

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2026 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн 10:00 цагт өөрийн байрэнд хуралдуулав.

Оролцсон нь :

Н.Соёмбо –ТУЗ-ийн дарга

Ц.Алтансүх – ТУЗ-ийн гишүүн

М.Алтанцэцэг –ТУЗ-ийн гишүүн

Н.Тулга – ТУЗ-ийн гишүүн

Э.Нороврinчин – ТУЗ-ийн гишүүн

Х.Анар – ТУЗ-ийн гишүүн

М.Адилбиш –ТУЗ-ийн гишүүн

Б.Нямдэлгэр –ТУЗ-ийн гишүүн

М.Азгүн,

Г.Даваажаргал ,

Б.Баттөгс ,

Б.Түмэнжаргал

Хурлын явц : Хурлын ирц 100 хувь байна ээлжит бус хурлыг эхлүүлье гэж Н.Соёмбо танилцуулав. Өнөөдрийн хурлаар ТУЗ-ийн дарга , ТУЗ-ийн гишүүд ,ТУЗ-ийн хараат бус гишүүдийг сонгож батламжлах болно.

М.Алтанцэцэг : Бид 2026 оны 04 дүгээр сард компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулсан болно. Энэхүү хурлаараа хэлэлцэх ёстой байсан нэг асуудлыг орхигдуулсан байсан. Иймд хэлэлцэх асуудлын 1 нь компанийн ТУЗ-ийн гишүүдийг шинээр сонгох юм. Удирдах дээд байгууллага санхүүгийн зохицуулах хорооны албан даалгаврын хүрээнд энэхүү ээлжит бус хурлыг хуралдуулж байна. Тус хурлаар хэлэлцэх 1-р асуудлын хүрээнд компанийн ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийг танилцуулья.

1. Наранцацралт овогтой Соёмбо. 1984 онд төрсөн Хүний их эмч мэргэжилтэй. Компанийн нийт хувьцааны 67,63 хувийг эзэмшдэг.

2. Цэрэндорж овогтой Алтансүх . 1978 онд төрсөн малын их эмч мэргэжилтэй. “Их Азар” ХХК-ийн ерөнхий захирал.
3. Махбал овогтой Алтанцэцэг 1958 онд төрсөн . Хүнсний инженер технологич мэргэжилтэй. 2008 оноос тус компанийн гүйцэтгэх захирлын албыг хашиж байна.
4. Хосбаяр овогтой Анар. 1987 онд төрсөн. Олон улсын харилцааны мэргэжилтэй. “Их загар” ххк- ийн захирал
5. Наранцацралт овогтой Тулга , 1987 онд төрсөн , Хуульч эрх зүйч мэргэжилтэй. Тус компанид ТУЗ-ийн гишүүн
6. Энхтөр овогтой Нороврinчин , 1983 онд төрсөн , Хуульч мэргэжилтэй “Наст трейд” ХХК-ийн хуульч
7. Мэнджаргал овогтой Адилбиш. 1979 онд төрсөн. Малын их эмч мэргэжилтэй. UB BET мал эмнэлэгийн малын их эмч.
8. Батбаяр овогтой Доржмягмар 1987 онд төрсөн. Эрүүл мэндийн эдийн засагч мэрэгжилтэй. “Яармаг моль” ХК-ийн гүйцэтгэх захирал,
9. Мөнхдүүрэн овогтой Азгүн. 1988 онд төрсөн Англи хэлний багш орчуулагч, Олон улсын ба улс төрийн шинжлэх ухаан судлаач мэргэжилтэй. Олон улсын хөрөнгө оруулалттай компанид механик-инженер ажилтай.

Компанийн ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байсан Баярсайханы Нямдэлгэр нь өөрийн эрхэлдэг бизнестэй холбоотойгоор Компанийн ТУЗ-ийн гишүүнээс чөлөөлүүлэх хүсэлтийг гаргасан байна.

2.Тус хурлаар хэлэлцэх бусад асуудлын хүрээнд компанийн эзэмшлийн ХУД-ийн 12-р хорооны нутагт байрлалтай 8,063 га газрын ашиглалтыг хангаж компанийн санхүүгийн чадамжид сайн нөлөө үзүүлэх шийдлийн талаар ярилцья.

Санал шүүмжлэл:

Н.Соёмбо: Гүйцэтгэх захирлын мэдээллийг сонслоо. Одоо мөрдөгдөж байгаа хуулийн хүрээнд хэлэлцэж,батлах асуудлууд байна. Компанийн ТУЗ-ийн гишүүнээр сонгогдох гишүүдийг дэмжиж байна. Мөн компанийн эзэмшлийн ХУД-ийн 12-р хорооны нутагт байх энэхүү газар дээр хойшлуулшгүйгээр үйл ажиллагаа явуулах, худалдан борлуулах, түрээслэх, төсөл төлөвлөгөө хэрэгжүүлэх үйл явцыг гүйцэтгэх удирдлагад үүрэг болгох саналтай байна. Хурлаас гарах шийдвэрийг хүлээн авахад татгалзах зүйлгүй.

Э.Нороврinчин: Сонгогдох ТУЗ-ийн гишүүдийн мэдээллийг сонслоо. Дэмжиж байна. ХУД-ийн нутагт байх компанийн эзэмшлийн газрын тухайд дорвитой шийдвэр гаргаж эдийн засгийн эргэлтэнд цаг алдалгүй оруулах шаардлагатай гэж үзэж байна. Хурлаас гарах шийдвэрийг хүндэтгэн хүлээн авна.

Х.Анар : ТУЗ-ийн гишүүдийн мэдээлэл болон бусад асуудлын тухай сонсож мэдлээ. Шинээр томилогдож байгаа ТУЗ-ийн гишүүдийг дэмжиж байна. ХУД-ийн 12-р хорооны нутаг дэвсгэрт байрлах газрыг санхүүгийн хувьд мөн үйл ажиллагааны эргэлтэнд яаралтай оруулж ажиллах нь зүйтэй. Хурлаас гарах шийдвэрийг хүлээн авна. Татгалзах зүйлгүй болно.

Н.Тулга : Энэхүү ээлжит бус хурлаар хэлэлцэж буй асуудлын хүрээнд бол компанийн ТУЗ-ийн гишүүдэд нэр дэвшигчдийг дэмжиж, зөвшөөрч байна. ХУД-ийн газрын тухайд үр өгөөжтэй үйл ажиллагааг даруйхан хийх хэрэгтэй. Бид жил бүр ярилцдаг гэвч үр дүнгүй байна. Үр дүн гаргаж компанийн эдийн засгийн чадамжид нөлөөлөх ажлыг хийх нь зүйтэй гэж үзэж байна. Хурлаас гарах шийдвэрийг хүлээн авахад татгалзах зүйлгүй.

М.Алтанцэцэг : Компанийн ТУЗ-д гишүүнээр сонгогдож байгаа хүмүүсийг дэмжиж байна. Олон талын ажил бизнес хийдэг хүмүүс байна. Энэ компанийн үйл ажиллагаанд сайнаар нөлөөлөх байхаа гэж бодож байна. Харин ХУД-ийн 12-р хорооны нутаг дэвсгэрт байрлалтай энэхүү газрын ашиглалтыг сайжруулах шаардлага зүй ёсоор гарч байна.дорвитой үйл ажиллагаа зохион байгуулж чадаагүй,бүрэн ашиглалтгүй байснаасаа болж бид 2 га гаруй хэмжээтэй газраа дүүрэгт өгсөн байгаа. Одоо ашиглах , ХАА –н чиглэлийн үйлдвэрлэл явуулах эсвэл хэсэгчлэн болон бүхлээр нь зарж борлуулах, түрээслэх,барьцаалах гэх мэтээр ашиглаж компанийн эдийн засгийн тулгамдсан асуудлаа шийдэж болох юм.

Бүгдээрээ хэлэлцэж гарц гаргалгааг гаргах шаардлагатай байна гэж үзэж байна. Хурлаас гарах шийдвэрийг хүлээн авна.

Ц.Алтансүх : ТУЗ-ийн гишүүдэд нэр дэвшигчдийг дэмжиж байна. ХУД-ийн нутагт байгаа компанийн эзэмшлийн газрын тухайд нэн яаралтай эргэлтэнд оруулах шаардлагатай. Компанийн эдийн засгийн чадамжийг нэмэгдүүлэх татварын өрийг барагдуулах зэрэгт түлхэц болох байдлаар шийдвэрийг гаргах хэрэгтэй юм байна гэж санагдаж байна. Тус хурлаас гарах шийдвэрийг хүндэтгэн хүлээн авна.

М.Адилбиш: Хэлэлцэж ярилцаж байгаа асуудлуудын талаар сонсож мэдлээ.

ТУЗ-ийн гишүүдийг дэмжиж байна. Компанийн эзэмшлийн газрын тухайд гарах шийдвэрийг хүлээн авна. Тусалж дэмжихэд татгалзах зүйлгүй гэдгээ хэлье.

Хурлаас гарах шийдвэрийг хүлээн авна.

Б.Доржмягмар : Компанийн ТУЗ-д нэр дэвшүүлэгчдийг дэмжиж байна. Бусад асуудалд хүчин чармайлт гарган ажиллах болно. Хурлаас гарах шийдвэрийг хүлээн авна. Татгалзах зүйлгүй гэв.

М.Азгүн : Тус компанийн ТУЗ-н гишүүнээр сонгогдох болсондоо талархалтай байна. Цаашид өрнөх компанийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцоно гэж бодож

байна.Хурлаас гарах шийдвэрийг хүлээн авна. Гэснээр санал шүүмжлэлийг тасаллаа.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ :

НЭГ : Компанийн ТУЗ-ийн гишүүнээр :

1. Н.Соёмбо
2. Э.Нороврinчин
3. М.Алтанцэцэг
4. Ц.Алтансүх
5. Н.Тулга
6. Х.Анар
7. М.Адилбиш
8. Б.Доржмягмар
9. М.Азгүн нарыг тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн сонгохоор,

Хоёр : Компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх, санхүүгийн тогтвортой байдлыг хангахад түлхэц болгох зорилгоор ХУД-ийн 12-р хорооны нутагт байрлалтай 8,063 га газрыг түрээслэх,бүхэлд нь буюу хэсэгчилсэн байдлаар худалдан борлуулах, үр өгөөжтэй төсөл төлөвлөгөө хэрэгжүүлэх ажлыг гүйцэтгэх удирдлага болон ТУЗ-ийн гишүүдэд үүрэг болгохоор,

Гурав. Б. Нямдэлгэрийг өөрийнх нь хүсэлтээр компанийн ТУЗ-ийн гишүүнээс чөлөөлөхөөр тус тус шийдвэрлэв.

Хурлыг 2026 оны 09 сарын 27-ны өдрийн 14:00 цаг 30 минутанд өндөрлүүлэв.

"MON GEO" INC
МОНГЕО ХК
УЛААНБААТАР ХОТ
ТТБ2687 2067153

Тэмдэглэл хөтөлсөн ...../ М.Алтанцэцэг /

Танилцсан нь : "MON GEO" INC

Н.Соёмбо –ТУЗ-ийн дарга .....

Ц.Алтансүх – ТУЗ-ийн гишүүн .....

МОНГЕО ХК

М.Алтанцэцэг –ТУЗ-ийн гишүүн .....

Н.Тулга – ТУЗ-ийн гишүүн .....

Э.Нороврinчин – ТУЗ-ийн гишүүн .....

Х.Анар – ТУЗ-ийн гишүүн .....

М.Адилбиш –ТУЗ-ийн гишүүн .....

Б.Доржмягмар –ТУЗ-ийн гишүүн .....

М.Азгүн –ТУЗ-ийн гишүүн .....